

# ***НИЙГМИЙН АЖИЛ-НИЙГМИЙН ХАЛАМЖ, ХАМГААЛАЛ***

## **ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН АЖЛЫН БАЙРНЫ ЧИГ ҮҮРГИЙН ШИНЖИЛГЭЭ**

*С. Туяа*

*Доктор (Ph. D.), дэд профессор*

*Шинжлэх ухаан, технологийн их сургууль*

*Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль*

*s.tuya@must.edu.mn*

**Хураангуй:** 2020 оны байдлаар Монгол улсын нийт хүн амын 31.7 хувийг эзэлж буй 15-34 насны залуучуудад чиглэсэн бодлого, арга хэмжээний нэг чиглэл болох Залуучуудын хөгжлийн төвийн үйл ажиллагаа, ажлын байрны чиг үүрэг, ажлын ачаалал, чиг үүргийн хуваарилалт, албан тушаалын шааодлагад тавигдах шалгуур үзүүлэлт, цалин урамшуулал зэрэг ажилтны өнөөгийн нөхцөл байдлыг шинжлэх зорилготой ажлын байрны чиг үүргийн шинжилгээг хийсэн. Судалгааг ЗХТ 25 ажилтнуудыг хамруулан тоон болон чанарын судалгааны аргыг ашиглан авсан өгөгдөл, тайлан, баримт бичиг зэрэг анхдагч хоёрдогч мэдээлэлд агуулгын шинжилгээ хийж, үр дүнгийн тайлбарлал, дүгнэлт зөвлөмж гаргасан. Хөгжлийн бодлогын баримт бичиг, хуулинд залуучуудад нийгмийн үйлчилгээг хүргэх, амьдралын гарааны үед байгаа өсвөр, залуучуудыг амьдралд бэлтгэх, хөдөлмөрийн даяарчлагдсан зах зээлд өрсөлдөх мэдлэг, үр чадвартай залуу үеийг төлөвшүүлэх, ажил хөдөлмөр эрхлэх хүсэлтэй залуучуудыг гарааны бизнес, үйл ажиллагаа эрхлэхийг дэмжих, ажлын үр чадвар эзэмшүүлэх, зөвлөгөө мэдээллийн орчинг бүрдүүлэх, амьдрах ухааны боловсрол олгох зэрэг чиглэлүүдийг тодорхойлж хэрэгжүүлж эхлээд байгаа ч хүний нөөцийн мэргэжлийн чиглэл, үр чадвар дутмаг, төвийн үйл ажиллагааны санхүү дутмаг, хууль эрх зүйн хэрэгжилт бэрхшээлтэй зэрэг асуудал байгаа нь судалгааны явцад харагдсан.

**Түлхүүр үгс:** залуучууд, залуучуудыг дэмжих бодлого, залуучуудын хөгжлийн төв

### **I. УДИРТГАЛ ХЭСЭГ**

Монгол улсад 35 хүртэлх насны хүүхэд, залуучууд нийт хүн амын 51.4 хувь, тэр дундаа 15-34 насны залуучууд 2019 оны байдлаар 32.8 хувь, 2020 онд 31.7 хувийг [1] эзэлж байна.

Хүн амд эзлэх хувийн жингээрээ ч хөдөлмөрийн насны хүн амын нэлээд хэсгийг 15-59 насныхан бүрдүүлж байгаа юм. Хэдийгээр хүн амын насны бүтцэд ахмад настны бүлгийн эзлэх хувь нэмэгдэх төлөвтэй байгаа ч 2040 он гэхэд манай улсын хүн амын хэтийн тооцоогоор 15-34 насныхан 29 хувийг эзлэхээр [2] байна. Залуучуудын өмнө бусад хөгжингүй болон хөгжиж буй орны залуучуудын нэгэн адил чанартай боловсрол, хувь хүний хөгжил, санхүүгийн үйлчилгээ, ажил хөдөлмөртэй байх, нийгмийн амьдралд тэгш хүртээмжтэй, идэвхи оролцоотой байх зэрэг тулгамдсан олон асуудал байсаар байна.

Улс орон бүр залуучуудад чиглэсэн тусгай бодлогыг хэрэгжүүлж байгаа ч хамрагдаж буй насны хувьд, нийгмийн үйлчилгээ нь ялгаатай байна. Европын холбооны “Залуучуудын хөтөлбөр” [3]-т залуу насны ангилалд 15-28 (зарим тохиолдолд 13-30 нас) нас, ихэнхдээ 15-34 насны залуучуудыг багтаан хөдөлмөр, боловсрол, хувь хүний хөгжил, аюулгүй орчныг бий болгох үйлчилгээг бодлогын арга хэмжээнд багтаан хэрэгжүүлдэг.

Манай улсын хувьд урт болон дунд хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа 2020-2050”, “Монгол улсын Тогтв ортой хөгжлийн үзэл баримтлал 2030”, эдийн засгийн “Турван тулгуурт хөгжлийн бодлого”, “Төрөөс хүн амын талаар баримтлах бодлого”, “2016-2020 оны ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөр”, 2020-2024 оны УИХ-ын ээлжит сонгуульд олонхи болсон МАН-ын сонгуулийн мөрийн хөтөлбөр, “Залуучуудын хөгжлийн үндэсний хөтөлбөр” баримт бичгүүдэд залуучуудын хөгжлийн талаар тусган, зөв зохистой институцийг бүрдүүлэн цаашид тогтолцоожуулах талаар бодлогын чиглэлүүдийг тусгасан байна. Энэ хүрээндээ Залуучуудын хөгжлийн Үндэсний болон салбар зөвлөлийг байгуулж, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийг батлан Залуучуудын хөгжлийн төв (цаашид “ЗХТ” гэх)-ийг аймаг, хот дүүрэгт бий болгож, төрийн үйлчилгээг хүргэж эхэлсэн юм. Залуучууд тэр дундаа зорилтот бүлгийн залуучуудын тулгамдаж буй асуудлыг арилгах, нийгэмд эзлэх байр суурь, оролцоог нэмэгдүүлэх зэрэг олон төрлийн үйлчилгээг хүргэхээр хуульчилсан. Залуучуудын хөгжлийн дэмжих тухай хууль хэрэгжиж эхэлснээр ЗХТ-д ажиллах гурван мэргэжилтний албан тушаалын жишиг тодорхойлолт (цаашид “АТТ” гэх)-ыг батлан, төрийн албан хаагчийн орон тооны бүтцийг бий болгох, тодорхой чиг үүрэг хэрэгжүүлэх эрх зүйн орчин бүрдсэн. Өдгөө хот аймаг, дүүрэг сумдад нийт 32 ЗХТ-д 99 ажилтан залуучуудын хөгжлийн бодлого, үйлчилгээнд тэднийг өргөн хүрээгээр татан оролцуулах, олон талт хэрэгцээг тусгасан арга хэмжээг хэрэгжүүлэх, орон нутгийн засаг захиргаа, ТББ, залуучуудын байгууллагуудад хамтын түншлэл, сүлжээ бий болгож залуучуудыг дэмжих чиглэлээр төр, хувийн хэвшлийн түншлэл, засаглалыг бэхжүүлэхээр ажиллаж байна.

ЗХТ-ийн мэргэжилтний ажлын байрны чиг үүрэг, ажлын ачаалал, төлөвлөн хэрэгжүүлж буй ажлууд, үйл ажиллагаа оновчтой, бүрэн хуваарилагдсан эсэх, давхардал хийдэл байгаа эсэх, албан тушаалын шаардлагад тавигдах шалгуур үзүүлэлт, цалин урамшуулал, ажилтны өнөөгийн нөхцөл байдалд агуулгын шинжилгээ хийсэн.

## II. ОНОЛ, АРГА ЗҮЙН ХЭСЭГ

Залуучуудын өмнө тулгамдаж буй олон асуудал шинэ биш бөгөөд төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засагтай нийгмийн тогтолцоонд ч томоохон интитуциар дамжуулан асуудлыг шийдвэрлэх бодлогын арга хэмжээг хэрэгжүүлсээр ирсэн туршлага манайд бий билээ. 1990 оноос хойших 20 гаран жилийн хугацаанд шинэ нийгмийн байгуулалтай нийцүүлэн “Төрөөс залуучуудын талаар баримтлах бодлого (1997)”, “Хүн амыг орон сууцаар хангах үндэсний хөтөлбөр (2005)”, “Итгэлийн мөнгө” шинээр гэрлэсэн залуу гэр бүлд зориулсан хөтөлбөр, “Залуу гэр бүл, шинээр төрсөн хүүхдэд олгох мөнгөн тэтгэмж”, “Өсвөр үе, залуучуудын хөгжлийн үндэсний хөтөлбөр (2006)”, “Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль (2017)”, “Залуучуудын хөгжлийн үндэсний хөтөлбөр (2019)”-ийг баталж, дэлхийн олон улс оронд хэрэгжиж буй залуучуудын хөгжлийн бодлогын арга хэмжээтэй адил төстэй чиглэлийг хэрэгжүүлж, тодорхолж байна. Хүн амын олонхийг бүрдүүлж буй залуучуудын бүлэгт чиглэсэн, тэдэнд тулгамдсан нийгмийн асуудлыг оновчтой шийдвэрлэх чадамжтай, үр дүнтэй бодлогыг цогцлоох, нэгэнт бий болгосон бодлого, арга хэмжээг хэрхэн, яаж, ямар институци, механизмаар хэрэгжүүлэх вэ гэдэг нь бодлогын үйл явцад чухал асуудал юм. Европын холбооны залуучуудын талаарх бодлогод дараах чиглэлийг дэлхийн олон улс орон мөн хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Үүнд:

- Залуучуудын асуудалд чиглэсэн бус харин боломж дээр суурилсан бодлогын стандарт, арга аргачлалыг боловсруулж, хөрөнгө оруулалт хийх;
- Залуучуудыг бодлогын стратеги боловсруулалтад оролцуулах, хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаархи залуучуудын санал бодлыг сонсох, тэднийг хамруулах;
- Залуучуудыг хөдөлмөрийн зах зээл, иргэний нийгмийн үйл ажиллагаанд бүрэн дүүрэн оролцох мэдлэг, ур чадвартай болгон хөгжүүлэх, суралцах туршлага хуримтлуулах боломж нөхцлийг бүрдүүлэх;

Үр нөлөө бүхий бодлогыг бүс нутгийн нийгмийн бүлэг, залуучуудад хүргэх, үр дүнтэй үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой бодлогыг тодорхойлохын тулд мэдээлэл дата цуглуулах системийг бий болгох зэрэг макро түвшинд бодлогын шинэчлэлийг бий болгож байна.

Залуучуудад чиглэсэн бодлогын хүрээнд тэдний эрх, оролцоо, залуучуудын сайн сайхан байдал, аюулгүй байдал, хамгаалал, хөдөлмөр эрхлэлт, гэмт хэрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ, бодлогыг сурталчилах систем зэрэг өргөн хүрээтэй асуудлыг багтаадаг.

Энэхүү бодлогын асуудалд эрүүл мэнд, хөдөлмөр халамж үйлчилгээ, боловсролын зэрэг холбогдох яамдын үйл ажиллагаа ч зангидагдах юм.

БНСУ-ын Залуучуудын бодлогын судалгааны хүрээлэнгээс “залуучуудын идэвхи оролцоог дэмжих агентлагийн судалгаагаар дэмжлэг, урамшуулал, шагнал нь залуучуудын сэтгэл зүй, нийгмийн ур чадвар, суурь чадамжийг дээшлүүлэхэд үр нөлөөтэй” болохыг тогтоожээ[4].

Түүнчлэн оролцооны үйл ажиллагааны үр дүнд сэтгэл зүйн эрүүл мэнд сайжирч, өөрийн үйл ажиллагаандаа хариуцлагатай, чадавхаа дайчилсан, өөрөөрөө бахархах, сурлагын дүн дээшлэхэд ихээхэн нөлөөтэй бөгөөд хувийн төлөвлөгөөгөө тэлэх хөгжлийн үр дүнг бий болгосон нь судалгаагаар нотлогдсон байна. [5]. Ялангуяа тэмцээн уралдаан, сургалт, үйл ажиллагаанд оролцсон залуучуудын дийлэнхи нь бүтээлч байдал, зан чанараа дээшлүүлж, тэр хэрээр нийгмийн сайн байдал сайжирсан [6] үзүүлэлтийн нотолдог.

Мэргэжлийн ур чадвар, төлөвшилтэй холбоотой харилцааны аливаа үйл ажиллагаа нь илүү идэвхитэй байх тусам ажил мэргэжлийн төлөвшилд эерэг нөлөө үзүүлдэг бөгөөд хариуцлага, хамт олны мэдрэмж, манлайлал дээшилсэн нь тогтоогдсон [7]. Энэ нь орон нутгийн сайн сайхан байдал эерэг өөрчлөлтөд авчирч, залуучуудын өөртөө итгэх итгэл, үнэлэмж сайжирч [8] байгаа нь судалгаанаас харагдсан. Төрөл бүрийн үйлчилгээ залуучуудад чиглэсэн арга хэмжээ нь тэдэнд эрэл хайгуул хийх, туршлага судлах боломж олгох, бие бялдарын болон тэсвэр тэвчээрийн зэрэг төрөл бүрийн чадварыг бий болгодог [9] хэмээн судлаачид үзэж байна. Gilbert&Terrell нар бодлогын шинжилгээний хүрээг үйлчлүүлэгч, үйлчилгээг хүргэх систем, системийн зохион байгуулалтын бүтэц, байршил, үйлчилгээ үзүүлэх мэргэжилтний ур чадвар, үйлчилгээний төрөл, хөтөлбөр, санхүү төсөв зэрэг талаас нь хийх нь асуудлыг илүүтэй ойлгох, бодлогын эрэл хайгуул хийхэд туслана[10] хэмээн үзсэн.

### **Ш. СУДАЛГААНЫ ХЭСЭГ**

Судалгааны хүрээнд дараах практик асуудлыг дэвшүүлсэн. Үүнд:

- 1) Чиг үүргийг хэрэгжүүлэхэд хууль эрх зүй, тогтолцооны тулгамдсан асуудал байна уу, “Бусдаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ”-ний давуу болон сул тал?
- 2) Залуучуудад нийгэм сэтгэл зүйн эрэлт хэрэгцээтэй хэрхэн нийцэж байна вэ?

- 3) Байгууллагын үндсэн зорилт, чиг үүргүүд, нэгж хэлтсийн чиг үүрэг нь албан тушаалын тодорхойлолтод бүрэн хуваарилагдсан уу? Орхигдсон болон давхардсан чиг үүрэг байна уу?
- 4) Нэгж доторх ажилтнуудын чиг үүрэг, ажлын ачаалал жигд хуваарилагдаж чадсан уу?
- 5) Ажлын байрны тодорхойлолтод заагдаагүй ажил үүргийг хэрэгжүүлж байна уу?
- 6) Одоогийн ажлын байрны тодорхойлолтод тавигдаж буй шаардлага нь тухайн албан тушаалын чиг үүргийг хэрэгжүүлэхэд хэр зэрэг нийцэж байна вэ?
- 7) Албан тушаалын нэршил, ангилал, зэрэглэл, цалин нь хэр зэрэг оновчтой томъёологдсон бэ? зэрэг асуудалд анхааран судалгааны ажлын үр дүнг нэгтгэн боловсрууллаа.

2020 оны 6 сарын 08-7 сарын 20-ны хооронд Улаанбаатар хотын 9 дүүрэг, 21 аймагт үйл ажиллагаа явуулж буй ЗХТ-ийн ажилтны ажлын байрны судалгаа, мэдээлэл, нээлттэй асуумж, ганцаарчилсан ярилцлага, ажлын тайлан, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, дүрэм, журам, тушаал, шийдвэр зэрэг мэдээллийн анхдагч, хоёрдогч эх сурвалж, өгөгдөлд суурилан шинжилгээ хийлээ.

Судалгаанд асуумж, ганцаарчилсан ярилцлага, баримт бичгийн судалгааны аргыг ашиглав.

*Хүснэгт 1. Судалгааны хамрах хүрээ, объект*

Арга зүй	Мэдээлэл цуглуулах	Түүврийн нэгж	Хамрах хүрээ	Түүврийн хэмжээ
Чанарын ба Тоон судалгаа	Асуумж судалгаа	ЗХТ-ийн ажилтан	Мөн талбарт	n=25
	Ганцаарчилсан ярилцлага	Аймаг, дүүргийн ГБХЗХХ-ийн дарга	Мөн талбарт	n=6
	Баримт бичиг	Бодлогын баримт бичиг, тайлан мэдээ, цахим мэдээлэл, ажлын байрны судалгаа мэдээлэл	Мөн талбарт	Багц материал

#### *Тоон судалгаа*

ЗХТ-ийн мэргэжилтны АТТ-д заасан албан тушаалын зорилго, зорилт, гүйцэтгэх чиг үүрэг, албан тушаалд тавигдах шаардлагад үндэслэн асуумжийг боловсруулж, 21 аймаг, 9 дүүргийн 32 ЗХТ-ийн N=99 ажилтнаас

n=25 оролцогчийг хамруулав. Асуумжид нийт 55 асуулт багтсан ба дараах агуулгатай байна. Үүнд:

А. Судалгаанд оролцогчийн ерөнхий мэдээлэлтэй холбоотой асуулт -9;

В. Үндсэн асуулт:

а. ЗХТ-ийн нийт ажилтан албан хаагчдад тавигдах нийтлэг шалгуур, чиг үүрэгтэй холбоотой асуулт-17;

б. Төрийн үйлчилгээний албан хаагчаар томилох эрх зүйн орчинтой холбоотой асуулт-2;

с. ЗХТ-ийн мэргэжилтэн, албан хаагчдын өнөөгийн байдал буюу хөдөлмөрийн нөхцөл, цалин урамшууллын системтэй холбоотой асуулт-17;

д. ЗХДГХ, Залуучуудын хөгжлийн хөтөлбөр, салбар зөвлөлийн дүрмийн хэрэгжилттэй холбоотой асуулт-6;

е. ЗХТ-ийн үйлчилгээний зардал болон бусад холбоотой асуулт-4 асуулт бүхий асуумжийг боловсруулан нөхцөл байдал, тулгамдаж буй асуудлыг үнэлэн үр дүнг нэгтгэсэн.

Судалгаанд оролцогчдын 96 хувь 39 хүртэл насны залуу ажилтан, үүнээс 84 хувь нь эмэгтэй, 16 хувь нь эрэгтэй, ажилтнууд 100 хувь дээд боловсролтой, 60 хувь нь 2 хүртэлх жил, 40 хувь нь 2-оос дээш жил ажилласан туршлагатай байна. Нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, багш мэргэжилтэй ажилтан нийт ажилтны 52 хувийг тус тус эзэлж байна.

#### *Чанарын судалгаа*

Тоон судалгааны мэдээллийг гүнзгийрүүлэх, агуулгад багтаагүй асуудлаар дэлгэрэнгүй мэдээлэл авах зорилгоор ганцаарчилсан ярилцлагын аргыг ашиглан чанарын судалгааг хийсэн. Чанарын судалгаанд дүүрэг, аймгийн ЗХТ-ийн мэргэжилтэн, ГБХЗХХ-ийн дарга нар 9 оролцогч хамрагдсан.

#### *Баримт бичгийн судалгаа*

Баримт бичгийн судалгааны аргаар залуучуудын хөгжил, оролцоог дэмжих чиглэлээр холбогдох бодлогын баримт бичиг, хууль эрх зүй, дүрэм журам, статистик мэдээ, мэдээлэл, судалгааны тайлан, гадаад улс орнуудын судлаачдын судалгааны тайлан, материал, төрийн бодлого, эрх зүй, байгууллагын үйл ажиллагааны талаарх цахим мэдээлэлд шинжилгээ хийсэн. Үүнд <http://www.dgyouth.kr/dgyouth/intro.asp>, ЕХ-ны цахим хуудас <https://eacea.ec.europa.eu/national-policies/sites/youthwiki/files/gdlfrance.pdf>, Статистикийн мэдээллийн нэгдсэн сан <http://www.1212.mn/>, Хуулийн нэгдсэн мэдээллийн систем болох [www.legalinfo.mn](http://www.legalinfo.mn), МУ-ын засгийн газрын хэрэг эрхлэх газрын цахим хуудас [www.cabinet.gov.mn](http://www.cabinet.gov.mn) болон дүүрэг,

аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй ЗХТ-ийн үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан холбогдох тоон мэдээлэл зэрэг эх сурвалж багтаж байна.

## IV. ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Залуучуудын хөгжлийг дэмжих, оролцоог хангах, тэдний эрх ашиг сонирхлыг хамгаалах, нийгмийн асуудалд хариу арга хэмжээ, үйлчилгээг хүргэх төрийн байгууллага, албан тушаалтны бүрэн эрх, чиг үүргийг УИХ, Засгийн газар, ХНХЯ-ны Хүн амын хөгжлийн газар, Залуучуудын асуудал эрхэлсэн төрийн байгууллага буюу Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, Залуучуудын хөгжлийн газар, аймаг, нийслэл, сум дүүргийн Засаг дарга тус бүрээр ЗХДТХ-ийн 4 дүгээр бүлэгт нарийвчлан хуваарилсан байдаг. Уг хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1-7.1.5 дугаар зүйлд:

7.1.1. Хувь хүний хөгжил

7.1.2. Боловсрол, соёл, урлаг, спорт, шинжлэх ухаан

7.1.3. Эрүүл мэнд

7.1.4. Хөдөлмөр эрхлэлт

7.1.5. Аюулгүй амьдрах, хөгжих орчин гэсэн таван чиглэлийг тусгаж өгсөн[11]. Залуучуудын хөгжлийг дэмжих төрийн бодлого, хууль тогтоомжийн дагуу эдгээр таван чиглэлийг хэрэгжүүлэх талаар Засгийн газарт болон холбогдох бусад байгууллагын салбар дундын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, шаардлагатай арга хэмжээ авах; залуучуудын эрх ашгийг хамгаалах, иргэний нийгмийн байгууллага, аж ахуй нэгж байгууллагыг оролцуулах; олон улсын байгууллагатай хамтран ажиллах чиг үүргийг яам, агентлаг, аймаг, нийслэл, сум дүүргийн холбогдох албан тушаалтнаас гадна “Залуучуудын хөгжлийн үндэсний зөвлөл”, орон нутагт “Залуучуудын хөгжлийг дэмжих салбар зөвлөл”, Залуучуудын хөгжлийн төв хариуцан ажиллах юм.

“Залуучуудын хөгжлийн үндэсний зөвлөл” нь ЗХДТХ-ийн 22.3-д заасны дагуу Ерөнхий сайдын 2018 оны 01 дүгээр сарын 03-ны 01 тоот захирамжаар Ерөнхий сайдаар ахлуулсан 29 хүний бүрэлдэхүүнтэй байгуулагдаж, МУЗГ-ын 2018 оны 01 дүгээр сарын 03-ны 4 дүгээр тогтоолийн нэгдүгээр хавсралтаар “Залуучуудын хөгжлийн үндэсний зөвлөлийн дүрэм”, хоёрдугаар хавсралтаар “Орон нутгийн салбар зөвлөлийн дүрэм”-ийг тус тус баталсан байна.

Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн (цаашид ЗХДТХ гэх) 20 дугаар зүйл 20.3 хэсгийн залуучуудад зориулсан нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулах

заалт, ЗХТ-ийн үйл ажиллагааны дүрмийн 6.1-6.31 дүгээр хэсэгт тус тус заасны дагуу үйл ажиллагааны чиглэлийг хүргэх зорилгоор:

1.Залуучуудын хөгжлийн салбар зөвлөл, хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн

2.Залуучуудын хөгжил, соён гэгээрүүлэх үйл ажиллагаа хариуцсан мэргэжилтэн

3.Зорилтот бүлгийн залуучууд, сургалт хариуцсан мэргэжилтэн гэсэн гурван ажилтны орон тоотой хүний нөөцийн баг бүрдүүлэн ажиллаж байна[12]. Эдгээр бүтцийг тухайн орон нутгийн залуучуудын асуудал эрхэлсэн захиргааны байгууллагын дарга холбогдох хууль тогтоомжийн хүрээнд томилж, чөлөөлөх, төвийн үйл ажиллагааны төлөвлөгөө, төсвийг батлах, хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргийг хүлээнэ. Төвийн өдөр тутмын үйл ажиллагааг байгууллагын дарга удирдаж, үйл ажиллагааны зохион байгуулалтыг ажилтан, албан хаагч хариуцан байгууллагын даргын өмнө хариуцлага хүлээхээр бүтэц тогтолцооны чиг үүргийг хуваарилжээ.

Төвийн ажилтнуудын АТТ-ын үлгэрчилсэн загвар, албан тушаалын ангиллыг Залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга (агентлаг) батлахдаа ЗХДТХ-ийн 20 дугаар зүйлийн 20.6 дахь заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.3.2 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 276 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар ЗХТ-ийн мэргэжилтний албан тушаалын ангилал, зэрэглэлийг ТҮ-6-аар, Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолын 9 дүгээр хавсралтыг үндэслэн ТАХ-ын ажилласан жил, ажил мэргэжлийн ур чадварыг харгалзан цалингийн шатлалыг тогтоох чиглэлийг баримтлан ажиллах чиглэл өгсөн [13] байна. АТТ-д ЗХТ-ийн Залуучуудын хөгжлийн салбар зөвлөл, хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн нь төрийн бодлого, шийдвэр, дүрэм, журмын хэрэгжилтийг хангахын тулд салбар дундын уялдаа холбоог хангах, зохион байгуулж, мэдээ мэдээлэл, тайлан бэлтгэх захиргааны шинж чанартай чиг үүрэгтэй бол Залуучуудын хөгжил, соён гэгээрүүлэх үйл ажиллагаа хариуцсан мэргэжилтэн, Зорилтот бүлгийн залуучууд, сургалт хариуцсан мэргэжилтний чиг үүрэг нь залуучуудад хувь хүний хөгжил, эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлт, орчин нөхцөлтэй холбоотой асуудлаар зөвлөн туслах, холбон зуучлах, сургалт явуулах, үйл ажиллагаанд оролцох боломжийг залуучуудад бий болгох зэрэг үйлчилгээ, технологийн шинж чанартай ажил үүргийг хэрэгжүүлэхээр тусгагдсан байна.

Хүснэгт 2. Залуучуудын талаарх бодлого хөтөлбөр албан  
тушаалд тусгагдсан чиг үүрэг

Албан тушаал	Залуучуудын хөгжлийн талаарх бодлого чиглэл	ЗХДТХуульд заасан үйлчилгээний чиглэл
<b>Залуучуудын хөгжлийн салбар зөвлөл, хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн:</b> <i>Залуучуудад хөгжил оролцоо, эрх хамгааллын талаарх төрийн бодлого, шийдвэр, дүрэм, журмын хэрэгжилтийг ханган ажиллах, салбар дундын уялдааг зохицуулах ЗХСЗ-ийн үйл ажиллагааг зохион байгуулах, СЗ-өөс гарсан шийдвэрийн хэрэгжилтийг хариуцан ажиллах, мэдээ тайланг нэгтгэх тайлагнах;</i>	Боловсрол, насан туршийн боловсрол, хувь хүний хөгжил  Эрүүл мэнд, нөхөн үржихүйн ойлголт мэдлэг төлөвшүүлэх	Хувь хүний хөгжил  Боловсрол, соёл, урлаг, спорт, шинжлэх ухаан  Эрүүл мэнд
<b>Залуучуудын хөгжил, соён гэгээрүүлэх үйл ажиллагаа хариуцсан мэргэжилтэн:</b> <i>Залуучуудын хөгжлийг дэмжих, нийгмийн хөгжил, шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцох боломжийг бүрдүүлэх, аливаа эрсдлээс урьдчилан сэргийлэх, эерэг хандлага, зөв дадал, хэвшилтэй, иргэн болж төлөвшиүүлэхэд чиглэсэн соён гэгээрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах ажлыг орон нутагт хариуцан хэрэгжүүлэх, үр дүнг тайлагнах;</i>	Өндөр технологи эзэмшсэн хөдөлмөр эрхлэгч, тогтвортой ажлын байртай байх	Хөдөлмөр эрхлэлт
<b>Зорилтот бүлгийн залуучууд, сургалт хариуцсан мэргэжилтэн:</b> <i>Залуучуудад чиглэсэн амьдрах ухааны болон гэр бүлийн боловсрол олгох сургалт зохион байгуулах, зорилтот бүлгийн залуучуудад хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд чиглэсэн зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах ажлыг орон нутагт хэрэгжүүлэх;</i>	Гэр бүлийн боловсрол, амьдралын чанар Орон сууцны бодлого	Аюулгүй амьдрах, хөгжих орчин

ЗХДТХ-ийн 20.7 дахь хэсэг, ЗХТ-ийн үйл ажиллагааны дүрмийн 2.6-д заагдсаны дагуу тухайн орон нутгийн ЗХДСЗ-ийн ажлын алба нь ЗХТ байхаар заасан. Залуучуудын хөгжлийн салбар зөвлөл, хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн, Залуучуудын хөгжил, соён гэгээрүүлэх үйл ажиллагаа хариуцсан мэргэжилтэн, Зорилтот бүлгийн залуучууд, сургалт хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргүүд жигд хуваарилагдсан ч салбар зөвлөлийн ажлын албаны нарийн бичгийн даргын чиг үүрэгтэй мэргэжилтний чиг үүрэг давхцаж хуваарилагдсан байгааг анхаарах нь зүйтэй. Тухайлбал: Залуучуудын хөгжлийн салбар зөвлөл, хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтний албан тушаалын чиг үүрэг нь дараах зорилтын хүрээнд хэрэгжиж байна. Үүнд:

- 1.ЗХДТХ, залуучуудын хөгжлийн талаар төрөөс баримтлах бодлого шийдвэрийн хэрэгжилтийг хангахад чиглэсэн үйл ажиллагааг тухайн орон нутагт зохион байгуулах, тайлагнах;
- 2.Залуучуудын хөгжлийг дэмжих салбар дундын үйл ажиллагааг орон нутгийн түвшинд уялдуулан зохицуулах, залуучуудын салбар зөвлөлийн ажлын албаны хэвийн үйл ажиллагааг хангах, салбар зөвлөлөөс гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хэрэгжилтийг тайлагнах, мэдээлэх;
- 3.Нэгжийн үйл ажиллагаатай холбоотой төлөвлөгөө, тайланг боловсруулах, хэрэгжүүлэх, тайлагнах, залуучуудын статистик мэдээ, тайланг нэгтгэх, мэргэжилтнүүдийн өдөр тутмын үйл ажиллагаанд арга зүйн дэмжлэг үзүүлэх;
4. Салбарын үйл ажиллагаанд залуучууд, иргэний нийгмийн оролцоог бий болгох хамтран ажиллах нөхцлийг бүрдүүлэх, холбон зуучлах, хамтран ажиллах
- 5.Тухайн албан тушаалын чиг үүргийг холбогдох хууль тогтоомж, дүрэм, журамд нийцүүлэн бүрэн эрхийн хүрээнд үр дүнтэй хэрэгжүүлэх зорилготой байна.

ЗХДСЗ, хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтний албан тушаалын 1 дүгээр зорилтын хүрээнд гүйцэтгэх “номын сангийн үйлчилгээ, хүртээмжийг нэмэгдүүлэх, цахимжуулах” чиг үүрэг нь Залуучуудын хөгжил, соён гэгээрүүлэх үйл ажиллагаа хариуцсан мэргэжилтний албан тушаалын 2 дугаар зорилтын хүрээнд гүйцэтгэх “номын сангийн үйлчилгээг залуучуудад хүртээмжтэй болгох ажлыг орон нутагт бусад холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулах” чиг үүрэгтэй давхцах шинжтэй байгааг аль нэг мэргэжилтний чиг үүрэгт шилжүүлэх нь давхардал, хийдэл үүсгэхгүй илүү оновчтой хуваарилалт болохоор харагдаж байна.

Энэхүү 2 дугаар зорилтын хүрээнд албан тушаалын гүйцэтгэх чиг үүргийн 4, 5, 6 дугаар хэсэгт салбар зөвлөлийн хуралдаантай холбоотой бэлтгэл ажлыг хангаж, хэлэлцэх асуудлын жагсаалт гаргах, холбогдох баримт бичгийг гишүүдэд хүргүүлэх; салбар зөвлөлийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохицуулах, хуралдааны бэлтгэлийг ханган гаргасан шийдвэрийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах, хяналт тавих тайланг нэгтгэх салбар зөвлөлийн тэргүүн, дэд тэргүүн, гишүүдийг мэдээллээр хангах; үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах, хагас жил болон жилийн эцсийн тайланг нэгтгэх, хэрэгжилтийг салбар зөвлөлөөр хэлэлцүүлэх зэрэг

албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэгтэй байх бөгөөд эдгээр чиг үүргийг салбар зөвлөлийн нарийн бичиг хэрэгжүүлэхээр дүрмэнд тусгагдсан байна.

Залуучуудын хөгжлийн салбар зөвлөлийн дүрмийн 2.3 дахь хэсэгт “Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга нь тухайн орон нутгийн залуучуудын асуудал эрхэлсэн нэгжийн дарга, суманд мэргэжилтэн байна” гэж заасны дагуу орон нутгийн ГБХЗХГ, хэлтсийн дарга нар салбар зөвлөлийн нарийн бичгийн үүргийг гүйцэтгэхээр тусгагдсан байна. Салбар зөвлөлийн нарийн бичгийн даргын чиг үүргийг ЗХТ-ийн Залуучуудын хөгжлийн салбар зөвлөл, хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн хэрэгжүүлэх үү?, тухайн орон нутгийн залуучуудын асуудал эрхэлсэн нэгжийн дарга, суманд мэргэжилтэн байх уу? гэдгийг хууль эрх зүйн хувьд оновчтойгоор өөрчлөх хэрэгтэй.

Түүнчлэн албан тушаалын гүйцэтгэх чиг үүргийн 4 дүгээр зорилтын 3, 5-д зааснаар “залуучуудын ажлын байранд холбон зуучлах, гарааны бизнес, ажил мэргэжлийн чиглэлээр зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах ажлын төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагааны хүрээнд зохион байгуулах”, “Залуу гэр бүлд тулгамдсан асуудал, бэрхшээлээ хамтран даван туулах, хууль зүйн болон сэтгэл зүйн зөвлөгөө өгөх үйлчилгээнд холбон зуучлах, дэмжлэг үзүүлэх бүлгийн уулзалт ярилцлага зохион байгуулахад иргэний нийгмийн байгууллагын оролцоог дэмжих, хамтран ажиллах” чиг үүрэгтэй байна. Эдгээр чиг үүрэг нь захиргааны шинж чанартай, салбар дундын хамтын ажиллагааг хариуцан ажиллах мэргэжилтэнд хуваарилагдсан байгаа нь төдийлөн оновчтой биш байна. Харин дээрх үйлчилгээг хүргэх нөхцөл боломжийг бүрдүүлэх, төрийн болон төрийн бус байгууллага, иргэний нийгмийн байгууллагын оролцоо хамтын ажиллагааг бий болгох, ажлын уялдаа холбоог сайтар нягтруулах ажлыг чиг үүрэгт түлхүү хуваарилах, тэрхүү хамтын ажиллагаанд тулгуурлан Залуучуудын хөгжил, соён гэгээрүүлэх үйл ажиллагаа хариуцсан мэргэжилтэн болон Зорилтот бүлгийн залуучууд, сургалт хариуцсан мэргэжилтэн нь залуучуудыг ажлын байранд холбон зуучлах, гарааны бизнес, ажил мэргэжлийн чиглэлээр зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах, залуу гэр бүлд тулгамдсан асуудал, бэрхшээлээ хамтран даван туулах, хууль зүйн болон сэтгэл зүйн зөвлөгөө өгөх үйлчилгээнд холбон зуучлах, дэмжлэг үзүүлэх бүлгийн уулзалт ярилцлага зохион байгуулах зэрэг мэргэжлийн нийгмийн ажлын технологид суурилсан үйлчилгээг хариуцан хэрэгжүүлэх нь АТТ-д заасан мэргэжил, албан тушаалын нэршилд илүү оновчтой байна.

**Залуучуудын хөгжил, соён гэгээрүүлэх үйл ажиллагаа хариуцсан мэргэжилтны** албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэгт дараах 4 зорилтыг хуваарилсан байна. Үүнд:

- 1.Залуучуудад хөгжлийг дэмжих тухай хууль, залуучуудын хөгжлийн талаах баримтлах бодлого, шийдвэрийн хэрэгжилтийг хангахад чиглэсэн үйл ажиллагааг тухай орон нутагт зохион байгуулах, тайлагнах;
- 2.Залуучуудын оролцоог хангах, хөгжлийг дэмжих үйлчилгээг төвийн дүрэм, холбогдох хууль, тогтоомжийн дагуу үзүүлэх;
- 3.Аливаа эрсдлээс урьдчилан сэргийлэх, эерэг хандлага, зөв дадал хэвшилтэй, ирнэн болж төлөвшүүлэхэд чиглэсэн соён гэгээрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах;
- 4.Тухайн албан тушаалын чиг үүргийг холбогдох хууль тогтоомж, дүрэм, журманд нийцүүлэн бүрэн эрхийн хүрээнд үр дүнтэй хэрэгжүүлэх зорилттой байна.

Энэхүү зорилтын хүрээнд албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэгт залуучуудын хөгжлийг дэмжих үйлчилгээ, сонирхлын клуб, зөвлөл, бүлгийг дэмжих, хувь хүн, бүлгийн хөгжил, гэр бүлийн боловсрол олгох уулзалт, чөлөөт ярилцлага, номын сангийн үйлчилгээг хүртээмжтэй болгох ажлыг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулах, залуучуудын чөлөөт цагийн арга хэмжээ, ардын уламжлал, түүх соёлын өвийг хамгаалах, ёс заншил, уламжлалт зан үйлийг хөгжүүлэх, залуучуудын сайн дурын болон хүмүүнлэгийн ажлын оролцоог дэмжих, залуучуудын оролцоог хангах, хууль зүйн туслалцаа, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээнд холбон зуучлах, зөв амьдралыг хэвшлийг төлөвшүүлэх нөлөөллийн арга хэмжээ, урьдчилан сэргийлэх зэрэг нийгмийн үйлчилгээг хариуцан гүйцэтгэхээр хуваарилалт хийсэн байна.

**Зорилтот бүлгийн залуучууд, сургалт хариуцсан мэргэжилтны** албан тушаалын зорилт нь:

- 1.Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль, зорилтот бүлгийн залуучуудын хөгжлийн талаар төрөөс баримтлах бодлого, шийдвэрийн хэрэгжилтийг хангахад чиглэсэн үйл ажиллагааг орон нутагт зохион байгуулах, тайлагнах;
- 2.Залуучуудад гэр бүлийн боловсрол олгох, амьдрах ухааны чадвар эзэмшүүлэх сургалт явуулах;
- 3.Зорилтот бүлгийн залуучуудыг хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, мэдээллээр хангаж, ажилд холбон зуучлах, залуучуудад хууль зүйн болон боловсрол, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд холбон зуучлах үйлчилгээ үзүүлэх, тайлагнах;

4. Тухайн албан тушаалын чиг үүргийг холбогдох хууль тогтоомж, дүрэм, журамд нийцүүлэн бүрэн эрхийн хүрээнд үр дүнтэй хэрэгжүүлэх;

Энэ хүрээнд албан тушаалын чиг үүргийн дагуу зорилтот бүлгийн залуучуудад голчлон анхаарч тэдэнд хүргэх нөхөрлөл, хоршоолол эрхлэх, гарааны бизнесийн сургалтад хамруулах холбогдох төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран цогц хөтөлбөр, соён гэгээрүүлэхэд чиглэсэн сургалт нөлөөллийн үе шаттай ажил, амьдрах ухааны чадвар олгох сургалт, эрүүл зан үйлийн сургалт, гэр бүлийн боловсролын сургалт, биеийн тамир, спорт, сэтгэл зүй, сэтгэл заслын үйлчилгээ, хорих ял эдэлж байгаа, хорихоос суллагдсан залуучуудад мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтад холбон зуучлах зэрэг урт хугацаанд тогтвортой үргэлжлэх үйлчилгээг хүргэхээр байна.

ЗХТ-ийн үйл ажиллагааны дүрмийн 5.1.8 дахь хэсэгт Сайн дурын ажилд холбон зуучлах үйлчилгээг үйлчилгээний нэг төрөл болгон зааж өгсөн. ХНХ-ын сайдын 2019 оны 03 сарын 28-ны өдрийн А/130 дугаар тушаалаар баталсан “Залуучуудын сайн дурын ажлын бүртгэх, баталгаажуулах журам”-ын 5.3 дахь хэсгийн “Сайн дурын ажил гүйцэтгэх хүсэлтэй залуучууд болон сайн дурын ажил хийлгэх сонирхолтой аж ахуйн нэгж, байгууллага, иргэнийг тухайн орон нутгийн ЗХТ-д бүртгэнэ”, 5.4 дэх хэсэг “Сайн дурын ажил хийх хүсэлтийг орон нутгийн ЗХТ сайн дурын ажил хийлгэх, хүсэл, сонирхол бүхий талд холбон зуучилна”, 5.5 дахь хэсэгт заасан “Залуучуудыг сайн дурын ажилд уриалах, сургалт нөлөөллийн ажил зохион байгуулах, сайн дурын ажилтнуудын чадавхийг бэхжүүлэх зэрэг арга хэмжээг орон нутгийн ЗХТ хариуцан гүйцэтгэнэ” гэсэн заалтууд ЗХТ-ийн дээрх 3 мэргэжилтны албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэгт журамд зааснаар тусгагдаагүй байгааг анхаарч, АТТ-д тусгах нь зүйтэй байна. Залуучуудын хөгжлийн салбар зөвлөл, хамтын ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтны АТТ-ын үлгэрчилсэн тодорхойлолтын гуравдугаар зорилтын хүрээний 6-д “Залуучуудын сайн дурын ажил хийх тухай мэдээллийн хариуцан бүртгэлжүүлэх”;

Залуучуудын хөгжил, соён гэгээрүүлэх үйл ажиллагаа хариуцсан мэргэжилтны АТТ-ын үлгэрчилсэн тодорхойлолтын хоёрдугаар зорилтын хүрээний 5-д “Залуучуудын хүмүүнлэгийн болон сайн дурын ажилд оролцох оролцоог дэмжих” гэсэн томьёоллоор чиг үүрэг хуваарилагдсан байх бөгөөд сайн дурын ажилд уриалах, сургалт, нөлөөллийн ажил зохион байгуулах, сайн дурын ажилтнуудыг чадавхижуулах зэрэг чиг үүрэг аль алинд нь тусгагдаагүй орхигдсон байна.

Сайн дурын үйл ажиллагаа нь залууст шинэ мэдлэг, ур чадвар, туршлага олж авах, хувь хүн өөрөө хөгжих, суралцах, цаашлаад нийгмийн эв нэгдэл, бүтцийг хамгаалах чухал үүрэгтэй бөгөөд манай оронд хараахан тогтолцоожоогүй байгаа энэхүү ажлыг их, дээд сургуулийн оюутан залуус, ЕБС-ийн сурагчдын дунд, төрийн албанд ажиллах хүсэл эрмэлзэлтэй олон залуучуудын дунд зохион байгуулах боломж бүрдэж байгаа нь сайшаалтай. Гагцхүү үүнийг хэрхэн яаж бүртгэлжүүлэх, холбох, цаг тооцох, давуу байдал болгон авч үзэх механизмыг боловсронгуй болгох, хэрэгжүүлэх чиг үүргийг ЗХТ-ийн мэргэжилтнүүдийн АТГ-д тодорхой тусгах, дагалдах дүрэм журам хэрэгтэй юм.

Нөгөө талаас ЗХТ-өөс хэрэгжүүлэх Амьдрах ухааны чадвар эзэмшүүлэх сургалт, Залуучуудын хүсэл сонирхолд нийцсэн клуб, зөвлөл, бүлгийг ажиллуулах; Гэр бүлийн боловсрол олгох, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх, бүлгийн уулзалт, чөлөөт ярилцлага зохион байгуулах; Залуучуудын сайн дурын ажлыг дэмжих, сайн дурын ажил хийх сонирхолтой залуучуудыг зохион байгуулах зэрэг чиглэлийн үйлчилгээг хэрэгжүүлэхдээ мэргэжилтны албан тушаалын чиг үүрэгт орон нутгийн болон залуучуудын нөөц, давуу тал, боломжийг тодорхойлох, залуучуудын дэмжлэгийн системийг хөгжүүлэх (community support), орон нутгийн нөөцийн зураглалыг (community mapping) гаргаж, түүнд түшиглэн хүмүүнлэгийн болон сайн дурын ажилд оролцох оролцоог тэлэх, нийгмийн ажлын үйлчилгээг зорилтот бүлгийн залуучуудад хүргэх, орон нутгийн “халуун цэг” (hot spotting)-ийн зураглалыг гаргаж архи, тамхи, мансууруулах бодис, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг хэрэгжүүлэх, залуучуудын сайн дурын бүлгийг (core group) үүсгэн хамтран ажиллах арга хэмжээг тусгаж, мэргэжилтнүүдийг арга зүй, аргачилалаар хангаж өгөх нь чухал хэмээн үзэж байна. Түүнчлэн залуучуудад зориулсан амьдрах ухааны чадвар эзэмшүүлэх сургалт, хувь хүний хөгжил, залуучуудын эрх ашгийг хөндсөн аливаа асуудлаар шийдвэр гаргах бүх түвшний үйл ажиллагаанд оролцох, хүсэл сонирхол, эрэлт хэрэгцээнд тулгуурласан сонирхлын клуб, зөвлөл, нөхөрлөл бүлгийн үйл ажиллагаа, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, гэр бүлийн боловсрол олгох зэрэг үйлчилгээг хэрэгжүүлэхдээ нас, хүйс, нийгэм сэтгэл зүйн онцлогийг харгалзан залуучуудыг дэд бүлэгт хуваан, хэрэгцээнд бүрэн нийцсэн арга хэмжээг хэрэгжүүлэх нь үйлчилгээний үр өгөөжийг нэмэгдүүлж байгааг олон улсын туршлага харуулдаг. Нийт үйлчилгээний 50 орчим хувийг эзэлж буй хувь хүний хөгжил сургалтын агуулга нь Амьдрах ухааны сургалтын 12 модулиар боловсруулагдсан байх ба зарим талаараа 20-оос дээш насны залуучуудын

хэрэгцээнд нийцэхгүй байх талтай байна. Зорилтот бүлгийн залуучуудын тухайлбал 15-19 насныханд амьдрах ухааны чадвар буюу эрүүл мэндийн боловсрол, спорт биеийн тамираар хичээллэх, чөлөөт цагаа өнгөрүүлэх, бие бялдар, бие биенийхээ ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрөх, эцэг эхүүхдийн харилцаа, сургууль-багш-сурагчдын харилцаа, дарамт, дээрэлхэлт, хүчирхийллийн харилцааны асуудал, түүнээс урьдчилан сэргийлэх, зайлсхийх ур чадвар, найз нөхдийн харилцаа, сургуулийн захиргаа, багш, эцэг эхийн хараа хяналт, дэмжлэгийн систем [14] зэрэг агуулгыг түлхүү багтаасан сургалтын агуулга хэрэгцээтэй бол 20-25 насны болон 26-34 насны залуучуудад ажил эрхлэлтэд зайлшгүй хэрэгтэй ур чадварыг хөгжүүлэхэд туслах, CV, резум бичих, тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдах боломжийн талаарх мэдээлэл өгөх, хөгжих боломж, суурийг санал болгох, хэлний сургалтууд, бизнес эрхлэх, гарааны компани байгуулах боломж, шинэ санаа, бүтээлч хандлагыг дэмжих, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, хамтдаа ажиллах орчин нөхцлийг бүрдүүлэх агуулга бүхий үйлчилгээ, нөлөөллийн үйл ажиллагааг хөтөлбөр хэлбэрээр урт хугацаанд хүргэх нь зүйтэй байна. Усан сан, фитнес, кофешоп, мини театр зэрэг аюулгүй амьдрах, хөгжих орчинг бий болгох хэрэгцээ ч мөн их байгаа нь судалгаанаас харагдаж байсан.

Олон улсын түвшинд хийгдэж буй залуучуудын ихэнх хөтөлбөр, үйлчилгээний агуулга, үйл ажиллагаа нь сургууль төвтэй хэрэгждэг ба үндсэн хичээлүүдийн агуулгад интеграцчилж багтаан агуулгыг тараан суулгасан байдаг боловч хэрэгцээт хөтөлбөр, үйлчилгээг хичээлээс гадуурх спорт, сонирхлын клуб хэлбэрээр багш, нийгмийн ажилтны удирдлаган дор хэрэгжүүлж болдог. Дээрх үйлчилгээг хэрэгжүүлэхдээ өсвөр залуучуудын эцэг эхэд мэдээлэл өгөх, тэднийг үйл ажиллагаандаа татан оролцуулах, бие биедээ туслах найз нөхдийн нөхөрлөл, дэмжлэгийг хэрхэн бий болгох, харилцааны ур чадвар, хүчирхийллийн эсрэг асуудалд давхар төвлөрөх нь үр дүнтэй байдаг байна[15].

***Бусад хэлтэс, албаны чиг үүргийн хуваарилалт, давхардлын талаар:***

Залуучуудын хөгжлийн асуудлаар төрийн болон төрийн бус олон салбартай зөвлөлдөх нь бат бэх түншлэлийг бий болгох ач холбогдолтой дээр асуудлыг шийдвэрлэх, хариу арга хэмжээ авах, урьдчилан сэргийлэх хамтын хүчээр бодлого, үйл ажиллагаанд тэдний оролцоог баталгаатай хангах арга зам юм. Ямар нэг байдлаар хамтын үйл ажиллагаанд байгууллагыг оролцуулах нь амаргүй ажил ч гэлээ гол гол байгууллагатай хэрхэн хамтран ажиллах саналыг авахгүй орхих нь залуучуудын хөгжлийн

төлөө хийж буй олон үйлчилгээ, үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж, байгууллагууд эцэстээ оролцохгүй татгалзах нөхцөл үүсэж болзошгүй. Залуучуудад чиглэсэн үйл ажиллагаа явуулж буй нийгмийн халамж, хамгаалал, эрүүл мэндийн болон боловсрол, хөдөлмөрийн мэргэжилтнүүдийн чадамжид суурилсан байр суурь, үзэл бодол, ур чадварыг нэгдсэн зорилго, нийтлэг стратегид суулгах шаардлагатай.

Өөрөөр хэлбэл залуучуудын хөгжлийн бодлогын чиглэлээр чухал үүрэг оролцоотой хууль зүй, боловсрол, хөдөлмөр, нийгмийн хамгаалал, цагдаа, төсөв санхүүгийн салбарууд хамтран хэрэгжүүлэх олон салбар дамнасан үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөөг боловсруулан ажиллах ёстой бөгөөд энэ арга зүй, аргачлал байхгүйгээс аль салбартай хэрхэн хамтрах, хэрхэн хийх вэ гэдэг асуудал үүснэ. Ийм нөхцөл байдал ЗХТ-ийн үйл ажиллагаанд бас харагдаж байна. ЗХДТХ-д заасан залуучуудын хөгжлийг дэмжих чиглэл, ЗХТ-ийн үйл ажиллагааны чиглэлд зарим салбар, хэлтэс, албаны чиг үүрэг, үйлчилгээтэй давцсан, ялангуяа хөдөлмөр, нийгмийн хамгаалал, эрүүл мэндийн салбарын зарим чиг үүрэг, үйлчилгээтэй үйл ажиллагааг уялдуулан холбож хамтын түншлэл, олон салбарын хамтарсан нэгдмэл төлөвлөлтийг бий болгох нь чухал.

Нийгмийн халамжийн тухайн хуулийн 18 дугаар зүйл “Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ”, 20 дугаар зүйлд заасан боловсролыг дэмжих үйлчилгээ, 21 дүгээр зүйлд заасан эрүүл мэндийг дэмжих чиглэлийн үйлчилгээ нь ЗХТ-ийн үйл ажиллагааны дүрмийн 6.26-д “Хорих ял эдэлж байгаа, хорихоос суллагдсан залуучуудыг мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтад холбон зуучлах, нөхөрлөл хоршоолол эрхлэх, гарааны бизнесийн сургалтад хамруулах холбогдох төрийн болон төрийн бус бизнесийн байгууллагатай хамтран цогц хөтөлбөр хэрэгжүүлэх”, 6.10-т “Зорилтот бүлгийн залуучуудад зориулсан хөдөлмөр эрхлэлт, халамжийн үйлчилгээнд холбон зуучлах”, 6.13-т “гарааны бизнесийн талаарх мэдээллээр хангах”, 6.14 “Номын сангийн үйлчилгээ, цахим ном хөтөлбөр” нь давхцдагаас байгууллага, мэргэжилтний хооронд үл ойлголцох байдал үүсгэдэг байна.

Залуучуудыг олон нийтийн оролцоонд түшиглэн хөгжүүлэх, амьдралын итгэл үнэмшил, хувь хүний хөгжлийг дэмжсэн сургалт, эрүүл мэндийн үйлчилгээнд холбон зуучлах, зорилтот бүлгийн залуучуудыг ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, хөдөлмөрийн ур чадварт сургах, ажилд зуучлах үйлчилгээг давхцуулахгүйгээр салбар дундын хамтын ажиллагаа, уялдаа холбоог бий болгосны үндсэн дээр үр өгөөжтэй хэрэгжүүлж болохоор байна.

Түүнчлэн залуучуудын салбарт хийгдэж буй судалгаа, шинжилгээний тайланг гол үүрэг бүхий яам албадад танилцуулах, бусад салбар яамдын мэргэжилтнүүдийг урьж сургалт сурталчилгаа хийх зэрэг санаачлага гаргах замаар хамтын ажиллагааг эхлүүлж болно. Энэхүү сайн туршлага Налайх дүүргийн ЗХТ-ийн үйл ажиллагаа, зохион байгуулалтаас харагдаж байсан. Салбарын мэргэжилтэн, албан тушаалтныг өглөөний цай, кофед урингаа хөгжлийн төвийн үйл ажиллагаагаа танилцуулах, хамтран ажиллах боломж чиглэлээ ярилцах зэргээр салбар хоорондын хамтын ажиллагааг өрнүүлж буй туршлага байна. Залуучуудын асуудал хариуцсан нэгж, салбарын албан тушаалтнууд хамтран ажилласнаар илүү үр өгөөжтэй шийдэж болох бодлогын чиглэл, асуудлаа жагсааж, эдгээр асуудлаар бусад салбарын дэмжлэгийг системтэйгээр, тууштай эрэлхийлэх стратеги баримтлах нь зүйтэй юм.

### ***Албан тушаалын чиг үүргийн хэрэгжилтэд гарч буй хүндрэлийн талаар***

Залуучуудын хөгжлийн чиглэлээр, тулгамдаад буй асуудлын хамгаалах хүчин зүйлсийг бэхжүүлэхэд орон байрны нөхцөл, нийгмийн хамгаалал, боловсрол, хөдөлмөр эрхлэлтийг сайжруулах бодлого, зохицуулалт, чиг үүрэг сайн нөлөөтэй болохыг олон улсын туршлага харуулдаг.

ЗХТ-ийн ажилтны АТТ-д заагдаагүй бусад ажилд оролцох, зохион байгуулж хариуцан ажиллах байдал түгээмэл байна. Тухайлбал:

- Байгууллагаас зохион байгуулж буй бүхий л үйл ажиллагаа, үүнд тэмдэглэлт баяр ёслолын ажиллагааг зохион байгуулах;
- Бага насны хүүхэд хөгжил, гэр бүл хамтарсан багт ажиллах;
- Хүүхэд хамгаалал “гэр эргэлт” хийх, байцаалт, шүүх ажиллагаанд оролцох, шинжээчийн дүгнэлт гаргах, зорилтот бүлгийн хүүхэд, залуучуудын гэр бүлд нөхцөл байдлын үнэлгээ хийх;
- Хурдан морины уралдааны ажилд оролцох;
- Эргүүл, илрүүлэлт хийх;
- Төрөл бүрийн тэмцээн уралдаан шүүх, хөглөх, хүүхдийн баяр, шинэ жилийн арга хэмжээ зохион байгуулах зэрэг тухайн цаг үеийн үйл ажиллагаа, арга хэмжээнд оролцох, зохион байгуулах байдлаар ажиллаж байна.

Нөгөө талаас АТТ-ын албан тушаалын чиг үүрэгт заагдсан боловч хийгдэхгүй орхигддог ажлууд мөн байна. Үүнд:

- Зорилтот бүлгийн иргэдтэй ажиллах үйл ажиллагаа;
- Залуучуудын нөхөрлөл, хоршоолол эрхлэх, гарааны бизнесийн сургалт;

- Хууль зүйн үйлчилгээ, эрүүл мэндийн холбон зуучлах үйлчилгээг иргэд ихэнхдээ тухайн байгууллагаас шууд авдаг учраас хийгдэхгүй орхигдох;
- Сэтгэл зүйн анхан шатны зөвлөгөө мэдээлэл авах;
- Залуучуудын сайн дурын ажил хийх тухай мэдээллийн бүртгэлжүүлэлт хийх ажил;
- Орон нутгийн статистик бүрдүүлэх зэрэг чиг үүргийг орхигдуулж байгааг судалгаанд оролцогчид дурьдсан. ЗХТ-ийн АТТ-д заагдаагүй чиг үүрэг гүйцэтгэх мөн чиг үүрэгт заагдсан боловч хэрэгжүүлж чадахгүй байгаагийн шалтгааныг ажилтнууд дараах хүчин зүйлтэй холбон тайлбарлаж байна. Үүнд:

Гадаад хүчин зүйл:

- Орон нутгийн Засаг дарга нар харьяа нутаг дэвсгэртээ залуучуудын хөгжлийг дэмжих, Залуучуудын салбар зөвлөлийг тэргүүлэн ажиллах, хууль тогтоомжийн хэрэгжилтийг харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулах, шаардагдах төсвийг тухайн шатны ИТХ-аар баталгаажуулж, хэрэгжилтийг хангах чиг үүрэгтэй ч бодит байдал дээр хангалтгүй байгаа;
- Салбар дундын хамтын ажиллагаа тэр дундаа ХХҮХ, өрхийн эмнэлэг, эрүүл мэндийн төв, хөдөлмөр эрхлэлтийн албанаас үзүүлдэг зарим үйлчилгээг ЗХТ-ийн үйл ажиллагааны чиглэлтэй хэрхэн уялдуулах, холбон нэгтгэх, хамтран ажиллах удирдлага, зохион байгуулалт байхгүй;
- Орон нутгийн залуучуудын идэвхи оролцоо хангалтгүй, албан бичгээр залуучуудыг хамруулах хэрэгтэй болох;

Дотоод хүчин зүйл:

- Ажиллах орчин нөхцөл, тоног төхөөрөмжөөр хангаагүй;
- Үйлчилгээ, үйл ажиллагааны зардал төсөвгүй;
- Урамшуулал, ур чадварын нэмэлт цалин хөшүүрэг байхгүй
- ЗХТ-ийн удирдлага, зохион байгуулалт, хүний нөөцийн бодлого саармагжсан;
- Орон тоог орон нутгийн бүтцэд оруулаагүй, “Бусдаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ”-г шийдвэрлэх, ажилтнууд тогтвор суурьшилгүй, солигдох, ажлаас гарах нь хэвийн үзэгдэл болсон;
- Ажилтнуудад хууль эрх зүйн мэдлэг, санхүүгийн мэдлэг, сургалт зохион байгуулах арга зүй, зорилтот бүлгийн иргэдтэй ажиллах технологи, нөхцөл байдлын үнэлгээ хийх, үйлчлүүлэгчтэй харилцаа холбоо тогтоох, ярианы болон харилцааны ур чадвар, ажлаа төлөвлөх, манлайлах, багаар ажиллах, нөлөөлөх, хурдтай ажиллах мэдлэг, арга зүй, ур чадвар дутах зэрэг хүчин зүйл нөлөөлж байгааг дурьдаж байна.

ЗХТ орон нутгийн залуучуудын оролцоог нэмэгдүүлэх, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, бусад салбар нэгж, хэлтэстэй чиг үүргийн давхцал үүсэхгүй байхаар ажлын төлөвлөлт, зохион байгуулалт хийх, салбарын хамтын ажиллагааг сайжруулах хэрэгтэй байна.

Түүнчлэн орон нутгийн залуучуудын идэвхи оролцоо, хүсэл сонирхол хангалтгүй байдаг гэсэн хандлагаас бус залуучуудад хүрч очиж ажил үйлчилгээг таниулах, эрэлт хэрэгцээ, сонирхол, асуудлыг судлах, мэдээллээр хангах өөрөөр хэлбэл нийгмийн үйлчилгээний маркетинг хийх, залуучуудын сүлжээг орон нутагтаа бий болгох шаардлагатай. Энд Залуучуудын хөгжлийн үндэсний болон салбар зөвлөлийн гүйцэтгэх үүрэг маш их бөгөөд ЗХДТХ-ийн 22 дугаар зүйл, ЗХТ-ийн үйл ажиллагааг уялдуулах Залуучуудын хөгжлийн үндэсний зөвлөлийн дүрмийн 1.1, Залуучуудын хөгжлийн салбар зөвлөлийн дүрмийн 1.1-д тус тус тодорхой заалтуудыг хуульчилсан.

Залуучуудын хөгжлийг дэмжих салбар дундын үйл ажиллагааг улсын болон орон нутгийн түвшинд уялдуулан зохицуулах, хэрэгжилтийг нэгдсэн удирдлагаар хангах чиг үүрэг хангалтгүй байгаа нь үйлчилгээг жигд хүргэхэд бэрхшээл үүсгэж, шийдвэрлэх шаардлагатай асуудал хуримтлагдахад хүргэж байна.

*Албан тушаалд тавигдах мэдлэг чадварын шаардлага* Залуучуудын хөгжлийн чиглэлээр ажиллах, аливаа асуудлаас урьдчилан сэргийлэх, үүссэн асуудалд хариу арга хэмжээ авахад мэдлэг чадвар сайтай хүний нөөц, системтэй дэмжлэг, ажилтнуудын сайн холбоо сүлжээ нь бодлого, стратегийн хэрэгжилтэд онцгой үүрэгтэй. Хүний нөөцийн чадавхийг хөгжүүлэхэд сургалтад хамрагдан зохих бэлтгэл хангасан байх нь чухал ба энэ нь холбогдох байгууллагын ажилтан, асуудал хариуцсан ажилтан, мэргэжилтэн, бодлого шийдвэр гаргагчдад хамааралтай асуудал билээ. Залуучуудын хөгжлийн чиглэлээр ажиллаж буй янз бүрийн салбарын мэргэжилтнүүд нэгдсэн ойлголттой болж, мэдлэг ур чадварын нийтлэг суурьтай байх нь үйлчилгээнд эерэг нөлөөтэй.

Залуучуудын хөгжлийн төвийн ажилтны албан тушаалын чиг үүргийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд дараах боловсрол, мэргэжилтэй хүний нөөц шаардлагатай болохыг АТТ-д зааж өгсөн байна (Хүснэгт 3).

*Хүснэгт 3. ЗХТ-ийн ажилтын албан тушаалд тавигдах шаардлага*

Шалгуур	Ажлын албаны нарийн бичиг	Сургалт, урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан ажилтан	Оролцоо хамтын ажиллагаа хариуцсан ажилтан
Боловсрол	Дээд, бакалавраас дээш	Дээд, бакалавраас дээш	Дээд, бакалавраас дээш
Мэргэжил	Эрх зүйч багш, төрийн удирдлага, нийгмийн ажилтан, сэтгэл зүйч	Нийгмийн ажилтан сэтгэл зүйч, эрх зүйч, багш	Эрх зүйч багш, төрийн удирдлага, нийгмийн ажилтан, сэтгэл зүйч
Мэргэшил	Нийгмийн салбарын хүүхэд залуучуудын чиглэлээр мэргэшүүлэх сургалт		
Туршлага	Ажлын туршлагатай бол давуу тал		
Ур чадвар	Баримт бичиг боловсруулах, хариуцлага хүлээх, шийдвэр гаргах, хүнийг хөгжүүлэх, харилцааны соёлтой байх, компьютерийн өргөн хэрэглээний программ ашиглах, дотоод гадаад сүлжээнээс мэдээлэл авах мэдлэгтэй байх, илгээх багаар ажиллах, монгол бичгийн дүрэм, найруулга, албан бичиг хэрэг хөтлөлтийн талаар мэдлэг, ур чадвартай байх		

**Боловсрол:** ЗХТ-д 2020 оны 7 сарын байдлаар төрийн үйлчилгээг хүргэн ажиллаж буй ажилтнууд 100 хувь дээд боловсролтой, их дээд сургуулийг бакалавр, магистрын зэрэгтэй төгссөн хүний нөөцийн баг бүрдсэн байна. Нийгмийн үйлчилгээг олон нийт, иргэдэд хүргэхэд 4 жилийн сургалттай их, дээд сургуульд суралцаж төгссөн, мэргэжил эзэмшсэн байх шаардлага дэлхийн улс орнуудын ижил ажил үйлчилгээ үзүүлж буй салбарын хүний нөөцийн стандарт шаардлагад тусгагдсан байдаг. Энэ шаардлагын дагуу МУ-д нийгмийн ажилтан бэлтгэж буй төрийн өмчийн 5, төрийн өмчийн бус 10 гаруй их, дээд сургуульд бакалавраас дээш зэрэгтэй мэргэжилтнийг төгсгөж, хөдөлмөрийн зах зээлд нийлүүлж байна.

**Мэргэжил:** Залуучуудын салбар зөвлөл, хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн, Залуучуудын хөгжил, соён гэгээрүүлэх үйл ажиллагаа хариуцсан мэргэжилтний мэргэжлийн шаардлагад Эрх зүйч, Багш, Төрийн удирдлага, Нийгмийн ажилтан, Сэтгэл зүйч мэргэжил эзэмшсэн байх, Сургалт, урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан ажилтны хувьд Нийгмийн ажилтан сэтгэл зүйч, эрх зүйч, багш мэргэжил эзэмшсэн байх шаардлагыг тавьсан байна. Албан тушаалын шаардлагын дагуу Нийгмийн ажилтан, Сэтгэл зүйч, Багш, Эрх зүйч, Төрийн удирдлага мэргэжил эзэмшсэн ажилтан нийт ажилтны 57.7 хувь, бусад мэргэжил эзэмшсэн ажилтан 42.3 хувийг бүрдүүлж байна. Ажилтнуудын эзэмшсэн мэргэжил салбарын төлөв байдлыг хүснэгтээр харуулав (Хүснэгт 4).

Хүснэгт 4. ЗХТ-ийн ажилтнуудын эзэмшсэн мэргэжлийн төлөв байдал  
(2020 оны 7 сарын байдлаар)

Нийгмийн ажилтан	Сэтгэл зүйч	Эрх зүйч	Багш	Бизнес удирдлага	Төрийн удирдлага	Сэтгүүлч	Эдийн засагч	Инженер	Бусад
15.8%	4.87%	14.6%	17.0%	6.0%	4.8%	6.0%	8.75%	6.0%	16.8%

Үндсэндээ ажилтны албан тушаалд тавигдах мэргэжлийн шаардлага, шалгуур үзүүлэлтийн дагуу хүний нөөцийн бүрдүүлэлт хийх шаардлагатай байгаа нь судалгааны явцад харагдсан. Түүнчлэн Залуучуудын хөгжил, соён гэгээрүүлэх үйл ажиллагаа хариуцсан мэргэжилтний мэргэжилд тавигдах шаардлагыг Зорилтот бүлгийн залуучууд, сургалт хариуцсан мэргэжилтэнд тавигдаж байгаа мэргэжлийн шалгууртай ижил болгох нь зүйтэй гэж үзэж байна. Учир нь ЗХТ-ийн нийгмийн үйлчилгээнүүд нь залуучуудын хөгжил, амьдрах ухаан, ур чадварыг хөгжүүлэх, тэдний ашиг сонирхол, эрэлт хэрэгцээг тодорхойлох, зан үйлд суурилсан үйл ажиллагаа явуулах, сайн дурын үйл ажиллагаа, хүмүүнлэгийн ажлыг дэмжих, тулгамдсан асуудал, бэрхшээлийн даван туулах сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, бүлгийн уулзалт ярилцлага зохион байгуулах, эрүүл мэнд, нийгмийн бусад үйлчилгээнд холбон зуучлах, хорт зуршил, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийгэмшүүлэх, уриалах, салбарын хамтын ажиллагааг хөгжүүлэх зэрэг олон талт нийгмийн ажил, үйлчилгээнд суурилдаг учраас мэргэжлийн мэдлэг, ур чадвар, дадал эзэмшсэн Нийгмийн ажил, Сэтгэл зүйч мэргэжилтэнгээр юуны өмнө мэргэжлийн багаа бүрдүүлэх нь зүйтэй. Мэргэжлийн баг, хүний нөөцийн чадвар, чадавхи нь тухайн байгууллагын үр дүнтэй үйл ажиллагааны чухал бүрэлдэхүүн хэсэг байдаг.

**Мэргэшил:** Нийгмийн салбар, хүүхэд залуучууд судлалаар мэргэшүүлэх чиглэлээр ажилтнуудын мэдлэг, арга зүй, ур чадварыг байнга дээшлүүлж, мэргэшүүлэн сургах шаардлага тавигдсан бөгөөд энэ хүрээнд бэлгийн цогц боловсрол олгох сургалт, гэр бүл төлөвлөлтийн чиглэлээрх мэдээллээр хангах, зөвлөгөө өгөх, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, мэргэжилтнүүдийн чадавхыг бэхжүүлэх, залуучуудад амьдрах ухааны боловсрол олгох, “Залуучуудын статистикийн нэгдсэн үзүүлэлт тооцох аргазүй”-н сургалт, Залуучуудад зориулсан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих шинэлэг үйлчилгээг үзүүлэх арга зүйг нэвтэрүүлэхэд нийслэл, 21 аймаг, 9 дүүргийн мэргэжилтнүүдийн чадавхийг бэхжүүлэх сайн дурын үйл ажиллагааг удирдах, чиглүүлэх, зохион байгуулах ур чадварыг олгох, сайн дурын үйл ажиллагааны сургагч багш бэлтгэх

сургалтыг зохион байгуулж хүний нөөцийн чадавхийг бэхжүүлж ирсэн байна. Гэсэн хэдий ч ажилтнуудад дараах чиглэлийн мэдлэг ур чадвараар мэргэшэх сургалтын хэрэгцээ байгааг илэрхийлсэн. Үүнд:

- Сургалт, үйл ажиллагаа зохион байгуулах арга зүйн зөвлөгөө мэдээлэл;
- Залуучуудад зөвлөгөө мэдээлэл хүргэх мэдлэг, ур чадвар, технологи;
- Сэтгэл зүйн засал зөвлөгөө өгөх арга техникийн сургалт, мэргэжлийн үйлчилгээг хүргэх мэдлэг ур чадвар;
- Зорилтот бүлгийн иргэдтэй харилцах ур чадвар, дохионы хэлний сургалт;
- Холбон зуучлах, хамтын ажиллагаа өрнүүлэх ур чадвар;
- Албан бичиг баримт боловсруулалт Жишээ нь: гүйцэтгэлийн төлөвлөгөө хэрхэн бичих;
- Санхүү, төсвийн талаарх мэдлэг, ур чадвар;
- Үүсгэсэн бүлгийн тогтвортой байдлыг хадгалах, цаашид урт удаан хугацаанд үргэлжлүүлэн ажиллуулах ур чадвар (бүлэгтэй ажиллах нийгмийн ажлын ур чадвар);
- Хууль эрх зүйн мэдлэгтэй мэргэшүүлэх сургалтын хэрэгцээ байна.

**Туршлага:** ЗХТ-ийн ажилтнуудын улсад ажилласан жил, төрийн албанд ажилласан жил, тухайн салбарт ажилласан жилийг харьцуулан дараах хүснэгтээр харууллаа (Хүснэгт 5).

*Хүснэгт 5. Албан хаагчдын ажилласан жил (улсад, төрийн албанд, ЗХТ-д, 2020 оны 7 сарын байдлаар)*

№	Хугацаа	Улсад ажилласан	Төрийн албанд ажилласан	Залуучуудын хөгжлийн чиглэлээр ажилласан
1	2 хүртэлх жил	43.9 %	67.1%	77.2%
2	3-5 жил	29.3%	20.2%	20.2%
3	6-8 жил	21.9%	12.7%	2.6%
4	9-дээш жид	4.9%	-	-

*Эх сурвалж: Ажилтнуудын судалгаа. Байгууллагын албан хэрэгцээний материал 2020*

Хүснэгтээс харвал ажилтнуудын 77.2 хувь нь залуучуудын хөгжлийн чиглэлээр ажлын гараагаа эхэлсэн, төрийн албанд 2 хүртэлх жил ажиллаж байгаа [16] харьцангуй туршлага багатай залуучууд байна.

**Ур чадвар:** Баримт бичиг боловсруулах, хариуцлага хүлээх, шийдвэр гаргах, хүнийг хөгжүүлэх, харилцааны соёлтой байх, компьютерийн өргөн хэрэглээний программ ашиглах, дотоод гадаад сүлжээнээс мэдээлэл авах мэдлэгтэй байх, илгээх багаар ажиллах, монгол бичгийн дүрэм, найруулга, албан бичиг хэрэг хөтлөлтийн талаар мэдлэг, ур чадвартай байх гэсэн Төрийн албан хаагчид тавигдах ур чадварын нийтлэг шаардлага АТГ-д тусгагдсан байна. Залуучуудын хөгжлийн болон тулгамдсан асуудал нь хялбар шийдэлтэй, энгийн асуудал биш юм. Өөрөөр хэлбэл цогц арга зүй,

үйлчилгээ хэрэгтэй бөгөөд энэ нь залуучуудыг хүрээлэн буй орчин, экологийн янз бүрийн түвшинд чиглэсэн үйлчилгээ хэрэгжүүлэхийг шаардана. Эдгээр үйлчилгээ, арга хэмжээ нь эдийн засгийн тэгш бус байдал, хот хөдөөгийн ялгаатай байдал, эрүүл мэнд, зан үйл, нийгмийн болон сэтгэцийн эрүүл мэндийн гээд олон эрсдэлт хүчин зүйлсийг анхаарсан байх шаадлага тулгардаг. Иймээс залуучуудын чиглэлээр ажиллаж буй ажилтан, мэргэжилтний АТТ-д заагдсан ур чадвараас гадна дараах хэд хэдэн ур чадварыг нэмж тусгах нь зүйтэй байна (Хүснэгт 6) .

*Хүснэгт 6. Залуучуудын чиглэлээр ажиллах ажилтны албан тушаалд тавигдах ур чадварын шаардлага<sup>1</sup>*

Залуучуудын салбар зөвлөл, хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн	Залуучуудын хөгжил, соён гэгээрүүлэх үйл ажиллагаа хариуцсан мэргэжилтэн	Зорилтот бүлгийн залуучууд, сургалт хариуцсан мэргэжилтэн
<ul style="list-style-type: none"> <li>➢ Нийгмийн ажилтан: Тохирох нөөцүүдийг тодорхойлох, үнэлэх;</li> <li>➢ Төрөл бүрийн мэдээллүүдийг цуглуулж, тайлбарлах;</li> <li>➢ Асуудлын шалтгаан, гүнзгийрэлт, тархалтыг тодорхойлох;</li> <li>➢ Давуу тал нөөц боломжийг тодорхойлох, түүнийг үнэлэх, түүнд тохирсон арга хэрэгслүүдийг сонгон ашиглах;</li> <li>➢ Орон нутагт шаардлагатай байгаа хөтөлбөр үйлчилгээг боловсруулах;</li> <li>➢ Нийгмийн үйлчилгээний чанар, үр өгөөжийг үнэлэх;</li> <li>➢ Харилцан итгэлцсэн үнэнч харилцааг бий болгох;</li> <li>➢ Үйлчлүүлэгчийн зан үйлийг өөрчлөх;</li> <li>➢ Багаар ажиллах;</li> <li>➢ Олон мэргэжлийн багт ажиллах чадвартай байх;</li> <li>➢ Бүлэг, олон нийттэй ажиллах, орон нутгийн нөөцийг тодорхойлох, холбох, ятган үнэмшүүлэх гэх мэт. Сэтгэл зүйч: сэтгэл зүйн байдалд дүгнэлт өгөх, ёс зүйн хэм хэмжээг баримтлах, үйлчлүүлэгч бүрийн онцлогт тохирсон үйлчигээ үзүүлэх гэх мэт.</li> </ul>		

Нийгмийн ажилтан, Сэтгэл зүйч мэргэжилд шаардагдах ур чадварыг АТТ-д нэмж оруулснаар эзэмшсэн мэргэжлийн ур чадварт тулгуурлан практикт ажиллаж, залуучуудад нийгмийн үйлчилгээг илүү үр өгөөжтэй хүргэх, мэдлэг ур чадварын хомсдолд бага өртөх, мэргэжлийн үнэт зүйл,

<sup>1</sup> Нийгмийн ажилтанд шаардагдах мэргэжлийн ур чадвар: ШУТИС-ийн Нийгмийн ажлын хөтөлбөрийн 092301 кодтой бакалаврын сургалтын хөтөлбөрийг 2014 оны 6 сард хөтөлбөрийн ерөнхий хороогоор хэлэлцүүлэн ШУТИС-ийн Ректор баталсан. Сургалтаар олгох ур чадваруудын жагсаалтыг Нийгмийн ажлын хөтөлбөрөөр эзэмших мэдлэг, ур чадварыг АНУ-ын National Association of Social workers and Clinical Social Work Standards Committee байгууллагуудаас 2005 онд гаргасан, АНУ-ын University of Wisconsin-Madison нийгмийн ажлын хөтөлбөрийн эзэмшүүлдэг мэдлэг, ур чадваруудыг үндэс болгосон бөгөөд CDIO арга зүйд тулгуурлан боловсруулсан. Сэтгэл зүйчид шаардагдах ур чадвар: <https://www.apa.org/ANU-ын сэтгэл зүйчдийн холбооны 2010 оны дүрэмд сэтгэл зүйч мэргэжлийн ур чадварыг тодорхойлсон байдаг>.

итгэл үнэмшилтэй мэргэжилтнээр хүний нөөцийн чадварлаг багийг бүрдүүлэх боломж нэмэгдэх юм.

Залуучууд сургалт, сайн дурын ажил, зохин байгуулагдаж буй аливаа үйл ажиллагаанд хангалтгүй, идэвхигүй байна гэсэн шүүмжлэл гарч байсан. Энэ нь залуучуудыг оролцоогүй гэхээсээ илүүтэйгээр тэдэнд мэдээллийг сайн хүргэх, төвийн ажилтнуудын зүгээс тухайн бүлэгт хүрч очих ажиллах зорилго тавих, давуу тал, нөөц боломжийг тодорхойлох, орон нутгийн онцлог, залуучуудын нэн шаардлагатай хэрэгцээг судлан үнэлэх, тохирсон арга зүй, аргачилалыг ашиглах, үйлчлүүлэгчийн асуудлыг олон талаас нь харах зэрэг техник технологийн ур чадварт тулгуурлан ажиллах шаардлагатайг харуулж байна.

#### **Албан тушаалын нэршил, ангилал, зэрэглэл**

ЗХТ-ийн үйл ажиллагааны дүрмийн 2.1-д заасны дагуу төвийн удирдлага бүтэц, зохион байгуулалтыг батлахдаа:

- Залуучуудын хөгжлийн салбар зөвлөл, хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн,
- Залуучуудын хөгжил, соён гэгээрүүлэх үйл ажиллагаа хариуцсан мэргэжилтэн
- Зорилтот бүлгийн залуучууд, сургалт хариуцсан мэргэжилтэн гэсэн албан тушаалын нэршилтэй гурван мэргэжилтний чиг үүргээр дамжуулан залуучуудын хөгжил, оролцооны үйлчилгээг хүргэхээр заасан байна. ЗХДТХ-ийн 20 дугаар зүйлийн 20.6 дахь заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.3.2 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтын 5.1-ийн дагуу ЗХТ-ийн АТТ-ыг шинэчлэн баталж мөрдөж байгаа ч орон нутгийн ГБХЗХГ болон хэлстээс албан тушаалын нэршлийн өөрчлөн баталсан, хууль дүрэмтэй зөрчилдсөн асуудал гарч байна. Тухайлбал, Архангай аймгийн ГХБЗХГ-ын даргын 2020 оны 05 сарын 26-ны өдрийн А/32 тоот тушаал болон Өмнөговь аймгийн Даланзадгад сумын ЗХТ-ийн АТТ-ыг жишээ болговол албан тушаалын нэршлийг өөрчлөн томъёолсон байгааг хүснэгтэд харуулав

*Хүснэгт 7. ЗХТ-ийн Албан тушаалын нэршил*

ЗХТ-ийн үйл ажиллагааны дүрмэнд заасан албан тушаалын нэршил	Зарим орон нутгийн ЗХТ-ийн АТТ-д баталсан албан тушаалын нэршил
Залуучуудын хөгжлийн салбар зөвлөл, хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн	Залуучуудын хөгжлийг дэмжих салбар зөвлөлийн ажлын албаны нарийн бичиг
Залуучуудын соён гэгээрүүлэх үйл ажиллагаа хариуцсан мэргэжилтэн	Залуучуудын хөгжлийн төвийн оролцоо, хамтын ажиллагаа хариуцсан ажилтан

Зорилтот бүлгийн залуучууд, сургалт хариуцсан нийгмийн ажилтан	Залуучуудын хөгжлийн төвийн сургалт, урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан ажилтан
--	--

Мөн мэргэжилтэн хэмээх нэршлийг ажилтан болгон өөрчилсөн байгаа нь маргаантай нөхцөл байдлыг үүсгэж байна. 2019 оны 7 сарын 3-ны өдрийн Засгийн газрын “Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай” тогтоол 276-д заасан төрийн үйлчилгээний бусад байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын зэрэглэлийн ТҮ-6-д багтаж буй “Засгийн газрын агентлагийн эрхлэх асуудлын хүрээнд ажилладаг төрийн үйлчилгээний төсвийн байгууллагын мэргэжилтэн” гэсэн томьёолол, түүнчлэн ЗХТ-ийн үйл ажиллагааны дүрмийн 2.1 дэх хэсэгт заасны дагуу “мэргэжилтэн” гэсэн нэршлийг хэвээр хэрэглэх үндэслэл байна.

Энэ талаар Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг ГБХЗХГ-ын даргын 2020 оны 01 сарын 08-ны өдрийн 01/06 тоотод ЗХТ-ийн Залуучуудын хөгжлийн салбар зөвлөл, хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн, Залуучуудын хөгжил соён гэгээрүүлэх үйл ажиллагаа хариуцсан мэргэжилтэн, Зорилтот бүлгийн залуучууд, сургалт хариуцсан мэргэжилтны албан тушаалын үлгэрчилсэн тодорхойлолтыг жишиг болгон баталж хэрэгжилтийг ханган ажиллах чиглэлийг хүргүүлсэн байдаг. Цаашид орон нутагт ЗХТ-ийн мэргэжилтны АТГ-ын үлгэрчилсэн тодорхойлолтыг мөрдөж, батлан ажиллах нь зүйтэй.

#### Цалингийн зардлын судалгаа

ЗХДТХ (2017) батлагдан 2018 оны 01 дүгээр сарын 01-ны өдрөөс хэрэгжиж эхлэхтэй холбогдуулан 2018 оны улсын төсөвт Залуучуудын асуудал хариуцсан 99 албан хаагчын цалин, байгууллага төлөх нийгмийн даатгалын шимтгэл (11%)-ийн зардал болох нийт 776488.2 мянган төгрөгийг батлуулан ажиллаж ирсэн байна.

“Бусдаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ”-гээр ажиллаж байгаа учраас 480.0-600.0 төгрөгний цалинтай ажиллаж ирсэн нь ажилтнуудын цалинд өгч буй үнэлгээ дундаж болон дунджаас доогуур байхад нөлөөлж байна (Хүснэгт 16). Үүнд:

- Үндсэн цалингийн шатлалд өгөх үнэлгээ-76 хувь
- Ижил төстэй салбартай харьцуулахад таны цалин-68 хувь
- Цалин хөлс зах зээлийн зарчимтай нийцсэн эсэх- 72 хувь
- Цалин хөлс нь ажил мэргэжлийн онцлогийг тусгасан байдал-64 хувь
- Цалин нь ажил хийх хөшүүрэг болдог эсэх-52 хувь

- Цалин нь ажлын чиг үүрэг, хариуцлагатай харьцуулахад хангалттай эсэх-65 хувь
  - Үндсэн цалин надад ажил хийх урамшуулал болдог-82 хувь тус тус дундаж болон дунджаас доогуур гэж үнэлсэн.
- Ажилтны цалин хөлсийг 2018-2020 оны инфляцийн түвшин, ам долларын ханштай харьцуулан Хүснэгт 8-д харуулав.

Хүснэгт 8. Цалин, урамшууллын системд мэргэжилтэн, ажилтны өгөх үнэлгээ

№	Үнэлгээний үзүүлэлт	Маш дээгүүр	Дунджаас дээгүүр	Дундаж	Дунджаас доогуур	Маш доогуур
1	Та өөрийнхөө авч буй цалинд өгч буй үнэлгээ	-	8%	24%	44%	8%
2	Үндсэн цалингийн шатлалд өгөх үнэлгээ	-	8%	32%	40%	4%
3	Ижил төстэй салбартай харьцуулахад таны цалин ямар түвшинд байна вэ?	-	16%	16%	36%	16%
4	Цалин хөлс зах зээлийн зарчимтай нийцсэн эсэх	-	12%	12%	32%	28%
5	Цалин хөлс нь ажил мэргэжлийн онцлогийг тусгасан байдал	-	8%	28%	16%	20%
6	Цалин нь ажил хийх хөшүүрэг болдог эсэх	12%	20%	20%	12%	20%
7	Цалин нь ажлын чиг үүрэг, хариуцлагатай харьцуулахад хангалттай эсэх	-	8%	21%	20%	24%
8	Үндсэн цалин надад ажил хийх урамшуулал болдог	4%	8%	32%	24%	16%


Судлаачийн боловсруулснаар

Хүснэгт 9. Инфляци, ам доллар, дундаж цалингийн өөрчлөлт, харьцуулалт

№	Үзүүлэлт	2018	2019	2020
1	Инфляцийн түвшин	8.1	5.2	3.3
2	Ам долларын ханш	2515.0	2727.3	2834.5 (7.16)
3	Дундаж цалин (ЗХТ)	560.1	551.0*	540.0**2
4	Ам долларын өөрчлөлт	2.2%	5.7%	3.0%
5	Дундаж цалингийн өөрчлөлтийн хувь (ЗХТ)	-	-6%	-4.9%

Эх сурвалж: [www.1212.mn](http://www.1212.mn), [www.nso.mn](http://www.nso.mn), [www.bloomberg.mn](http://www.bloomberg.mn), [www.cabinet.gov.mn](http://www.cabinet.gov.mn)

<sup>2</sup> \*, \*\* Байгууллагаас төлөх НДШ 2019-2020 онд нэмэгдсэнээс шалтгаалан цалин буурсан.



Зураг 1-т 2018-2020 оноор инфляци, ам доллар, дундаж цалингийн өөрчлөлтийг хувиар илэрхийлэн харьцуулан харуулав.

Зураг 1. Инфляци, ам доллар, дундаж цалингийн өөрчлөлтийн харьцуулалт (хувиар)  
Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 2020 оны 1 сарын 1-ний өдрөөс эхлэн 420.0 төгрөгөөр шинэчлэгдэн тогтоогдсон ба 2018 онтой харьцуулбал 33.3-75 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Хүснэгт 9. ХХДХ, дундаж цалин (улс), дундаж цалин (ТАХ), дундаж цалин (ЗХТ) харьцуулалт (төгрөгөөр)

№	Үзүүлэлт	2018	2019	2020
1	Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ	240.0	320.0	420.0
2	Дундаж цалин (улс)	1.002.9	1.124.3	1.200.0
3	Дундаж цалин (ТАХ)	804.0	922.8	1.070.0
4	Дундаж цалин (ЗХТ)	560.1	551.0	540.0

Эх сурвалж: [www.1212.mn](http://www.1212.mn), [www.nso.mn](http://www.nso.mn), [www.bloomberg.mn](http://www.bloomberg.mn), [www.cabinet.gov.mn](http://www.cabinet.gov.mn)

Хүснэгт 10. ХХДХ, дундаж цалин (улс), дундаж цалин (ТАХ), дундаж цалин (ЗХТ) өсөлтийн харьцуулалт (хувиар)

№	Үзүүлэлт	2018	2019	2020
1	Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ өсөлтийн хувь	0%	33.3%	75%
2	Дундаж цалингийн өсөлтийн хувь (улс)	-	8.1%	10.9%
3	Дундаж цалингийн өсөлтийн хувь (ТАХ)	-	8%	8%
4	Дундаж цалингийн өсөлт (ЗХТ)	-	-6%	-4.9%

Эх сурвалж: [www.1212.mn](http://www.1212.mn), [www.nso.mn](http://www.nso.mn), [www.bloomberg.mn](http://www.bloomberg.mn), [www.cabinet.gov.mn](http://www.cabinet.gov.mn)

“2020 оноос мөрдөгдөж эхэлсэн нийгмийн даатгалын тухай хуулиудад орсон нэмэлт өөрчлөлтүүд”-ээр байгууллагаас төлөх НДШ 2019-2020 онд нэмэгдсэнээс шалтгаалан “Бусдаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ”-гээр гэрээлэн ажиллаж байгаа ажилтнуудын дундаж цалин 560.0-аас 540.0 буюу 2019-2020 онд -6-аас -4.9 хувиар буурсан үзүүлэлттэй байна (Хүснэгт 9,10-аас харна уу). Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 2018 онтой харьцуулахад 75 хувь, дундаж цалингийн өсөлттэй харьцуулахад 10,9

хувь, ТАХ-ын дундаж цалингийн өсөлт 8 хувь тус тус өссөнтэй харьцуулахад үндсэн цалин ажил хийх урамшуулал маш доогуур байгаа юм.

## Ү. ДҮГНЭЛТ

ЗХДТХ-ийн дагуу орон нутаг, сум дүүрэгт залуучуудын хөгжлийн бодлогын хэрэгжилтийг ханган ажиллаж буй ЗХТ-ийн ажлын байрны чиг үүргийг шинжилж дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

① Залуучуудын хөгжлийн салбар зөвлөлийн дүрмийн 2.1-г салбар зөвлөлийн тэргүүн Засаг дарга, дэд тэргүүн Засаг даргын нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч байна гэсэн хуулийн заалтын дагуу Залуучуудын хөгжлийн дэмжих салбар дундын үйл ажиллагааг тухайн орон нутгийн түвшинд уялдуулан зохицуулах, нэгдсэн удирдлагаар хангах чиг үүргийн хэрэгжилт зарим орон нутгуудад сул байна.

② ЗХТ-ийн үйл ажиллагааны дүрмийн 9.3 дугаар заалтын дагуу улсын болон орон нутгийн төсөв, олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрийн санхүүжилтээр төсөв бүрдүүлэхээр байгаа ч ихэнх ЗХТ-д хэрэгжихгүй үйл ажиллагааны төсөв, зардалгүй байна.

③ Хороо дүүрэг, орон нутгийн засаг захиргааны дэмжлэг сул, салбар дундын хамтын ажиллагааг уялдуулан зангидагдаж чадахгүйгээс зарим чиг үүрэг давхардах, ажил хийдэх асуудал байна.

**Албан тушаалын чиг үүрэг:** ЗХТ 3 ажилтантай байхаар ЗХТ-ийн үйл ажиллагааны дүрмэнд заасан бөгөөд АТТ-д ажилтан бүрийн албан тушаалын чиг үүрэг, хариуцах ажлын хуваарилалтыг оновчтой тодорхойлсон ч зарим давхцал, асуудал байна. Үүнд:

① АТТ-ыг ЗХДТХ-ийн 20 дугаар зүйлийн 20.6 дахь заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.3.2 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолын хавсралтын 5.1-ын дагуу шинэчлэн баталж мөрдөж байгаа бөгөөд зарим орон нутгийн ЗХТ-үүд харилцан адилгүй, мэргэжилтнүүдийн албан тушаалын нэршил өөрөөр томъёологдсон, ажил үүргийн хуваарь тодорхой бус байна.

② ЗХТ-ийн үйл ажиллагааны чиглэлд заагдсан үйлчилгээ тухайлбал, хувь хүний хөгжлийг дэмжих сургалт, эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, холбон зуучлах үйлчилгээ нь ХХҮХ, эрүүл мэндийн төв, сургалтын байгууллагаас хэрэгжүүлдэг зарим чиг үүрэгтэй давхцдаг ба салбар дундын хамтын ажиллагаа, уялдаа холбоог сайжруулах, үйлчилгээний орхигдоод байгаа талыг судлах, хамтрах ажиллагаа дутмаг байна.

③ Хүний нөөцийн бүрдүүлэлт зохих түвшинд байгаа ч АТТ-д заагдаагүй мэргэжилтэй ажилтан нийт ажилтны 50 хувь буюу тал хувийг эзэлж байгаа

бөгөөд энэ нь үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар, дадал дутагдах, ажилдаа сэтгэл ханамжгүй байх, ажлын тогтвор суурьшил алдагдах зэргээр ЗХТ-ийн үйл ажиллагаанд нөлөөлөх талтай.

#### **Ажилтны цалин урамшуулал:**

①ЗХТ, залуучуудын чиглэлээр ажиллаж буй хүний нөөцийг тогтвор суурьшилтай ажиллуулах, тэдний цалин хөлс, холбогдох нэмэгдлийг хууль тогтоомжид нийцүүлэн олгох, ажилтан албан хаагчдыг сургаж, мэргэшүүлэхэд анхаарах;

②Урт хугацаандаа үр нөлөөгөө хадгалах тогтвортой, системтэй бүтэц, институцийг бий болгохын тулд Залуучуудын үндэсний болон салбар зөвлөлийн хуралдааныг тогтмолжуулах, холбогдох бусад салбарын оролцоог хангаж, хамтран ажиллах нэгдсэн төлөвлөгөөг гаргах, удирдлагаар хангах;

③Залуучуудын хөгжлийн чиглэлээр уялдаа холбоо сайтай, илүү системтэй үр дүнтэй үйлчилгээг бий болгохын тулд бодлого, хөтөлбөр, үйлчилгээний зардал нөөцийн хуваарилалттай холбоотой шийдвэр гаргах хүмүүсийг мэдээллээр хангах, идэвхижүүлэх, орон нутагт нийгмийн хамгаалал, хууль зүй, боловсрол нийгмийн хамгаалал, хөдөлмөр, соёл, байгаль орчин зэрэг залуучуудын хөгжил, төлөвшил, боловсролыг асуудлыг хариуцаж буй салбаруудад залуучуудын асуудал, чиглэсэн бодлогын чухлыг бүхий л түвшинд сайтар ойлгуулах, олон салбар дамнасан үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөөтэй байх;

④Үйлчилгээг хүргэхдээ 15-34 насны залуучуудын бүлгийг дотор нь нас, хүйс, сэтгэл зүй-бие махбодь-оюун санааны онцлог байдлаар буюу 15-19 нас (ЕБС-ийн ахлах сургуулийн үе), 20-24 нас (оюутан амьдралын үе), 25-29 нас (амьдралын гарааны эхэн үе), 30-34 нас (гэрлэлт, ажил хөдөлмөрийн амьдралын үе)-аар ангилж, амьдралын аль үед ямар үйлчилгээ нэн хэрэгцээтэй болохыг тодорхойлж боловсрол, хувь хүний хөгжил, нийгмийн оролцоо, хамтын ажиллагаа, ажлын ур чадварыг хөгжүүлэх тохирсон үйлчилгээ, хөтөлбөрийг төлөвлөн хүргэх, хэрэгжүүлэх, стандартчилах нь зүйтэй.

⑤Залуучуудын хөгжлийн үйлчилгээг урт хугацаанд тогтвортой үргэлжлэх, илүү үр өгөөжтэй хөтөлбөр хэлбэрээр хэрэгжүүлэх нь оновчтой.

#### **НОМЗҮЙ**

ҮХС, <http://www.1212.mn>

Монгол улсын хүний хөгжлийн илтгэл 2016: Ирээдүйн сайн сайхны төлөө: Монгол улсын хөгжилд залуучуудын оролцоо. УБ. 2016 он. Хуу 16

<http://ec.europa.eu/youth/youth-in-action-rogramme/doc74 en.htm>

- 한국청소년활동진흥원. (2011). 국제청소년성취포상제 포상담당관 교육교재.
- Maran, D.A., Zero, G., Bianchetti, A. & Zanotta, T. (2009). *Serving others and gaining experience: A study of university students participation in service learning. Higher Education Quarterly* 63 (1). 46-63.
- 오세비, 문성호. (2012). 국제청소년성취포상제 참여청소년의 활동경험에 관한 연구. *청소년학연구*, 19(11), 249-270.
- 김우철, 임순선, 한상철. (2011). 국제청소년성취포상제 활동경험과 진로성숙도와의 관계. *교육학논총*, 32(1), 21-39.
- 장근영, 백혜정, 김용대, 김태우(2011). 국제청소년성취포상제 장기종단 효과성연구 1: 연구계획 및 예비조사. 서울: 한국청소년활동진흥원 한국청소년정책연구원
- 최경학. (2015). 국제청소년성취포상제 탐험활동이 청소년의 자이탄력성에 미치는 효과. *중앙대학교 사회발대학원 석사학위논문*
- 박영미, 김경명. (2007). 지방공공복지 전달체계 개편과정에 관한 분석. *지방정부연구*. 11(4). 223-245.
- Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль. УБ. 2017 он
- Залуучуудын хөгжлийн төвийн дүрэм. ГБХГХГ-ын даргын тушаал. 2019 сарын 06 сарын 05-ны өдөр А/137. УБ хот.
- МУЗГ-ын тогтоол. Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай. 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдөр. А/472, 9,10 дугаар хавсралт. УБ хот. МУЗГ-ын тогтоол. Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай. 2019 оны 7 сарын 3-ны өдөр. А/276. УБ хот.
- ДемоКрайзи залуусын төв. (2018). Залуучуудын дундах хүчирхийллийн асуудлыг илрүүлэх нь судалгаа.
- ДЭМБ (2018). *INSPIRE* гарын авлага: 7 стратегийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа. Ажилтнуудын судалгаа. Байгууллагын албан хэрэгцээний материал 2020.